

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/04/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichnkhорlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ЦАГААН-ҮҮР СУМЫН ЗАСАГ ДАРГА
ДАРГА А.БАТМӨНХ ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793. Цахим илүүдэл: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024 03 25 № 01/270
танай _____ -ны № _____ -т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/эмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 57.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитаар 2,240.3 сая төгрөгийн бүртгэл, тайлагналтай холбоотой алдааг залруулж, орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь биелүүлээгүй болон хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой 48.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Цагаан-Үүр сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 80 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0724040682

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЗРДЭНЗБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,822,780.9	1,309,958.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,237,896.8	684,260.9
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	77,653.0	55,565.8
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	404,671.6	455,772.1
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	102,559.5	114,359.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,052,799.0	1,525,118.3
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	87,000.0	154,704.3
37300	Урт хугацаат зээл		87,000.0	154,704.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	965,799.0	1,370,414.0
39200	Биет хөрөнгө		869,717.2	1,242,194.0
39300	Биет бус хөрөнгө	13	96,081.8	128,220.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,875,579.9	2,835,076.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		5,123.5	22,593.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	5,123.5	22,593.9
41300	Өглөг	17а, 17б	5,123.5	22,593.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,870,456.4	2,812,482.7
51	Засгийн газрын хувь оролцоо		2,870,456.4	2,812,482.7
51100	Засгийн газрын оруулсан капитал		5,320,570.3	5,352,906.3
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		2,221.9	2,221.9
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		33,281.0	31,830.6
51200	Хуримтлагдсан үр дүн		-2,539,048.3	-2,625,964.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		53,431.5	51,488.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,875,579.9	2,835,076.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,440,779.30	1,617,916.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,259,808.30	430,420.4
110	Орлогын албан татвар		169,469.90	227,575.2
1100	Хувь хүний орлогын албан татвар		184,917.90	236,648.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-15,448.10	-9,073.1
113	Хөрөнгийн албан татвар		13,935.60	16,998.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж		1,076,402.80	185,847.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	425,719.70	232,993.4
120	Нийтлэг татварын бус орлого		425,719.70	222,343.4
121	Хөрөнгийн орлого		0	10,650.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		755,251.40	954,503.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,063,879.90	1,500,346.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,063,879.90	1,500,346.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		997,750.30	1,234,303.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		363,475.40	477,129.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		46,242.00	60,880.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		186,352.10	48,176.9
2104	Хангамж, бараа материалын зардал		46,944.30	44,108.1
2105	Нормативт зардал		0	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		35,238.60	3,000.0
2107	Томилолт, зочны зардал		6,180.00	8,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		156,975.70	436,629.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		156,342.20	156,379.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		66,129.60	266,042.7

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,376,899.40	117,570.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		2,404,589.00	258,140.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-1,027,689.60	-140,570.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,194,734.00	1,601,557.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,259,808.30	430,420.4
110	Орлогын албан татвар	169,469.90	227,575.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	184,917.90	236,648.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-15,448.10	-9,073.1
113	Хөрөнгийн албан татвар	13,935.60	16,998.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,076,402.80	185,847.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	58,378.50	24,597.9
1181	Газрын төлбөр	7,749.90	42,639.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,010,274.40	118,609.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	179,674.30	210,604.9
120	Нийтлэг татварын бус орлого	179,674.30	199,954.9
121	Хөрөнгийн орлого	0	10,650.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	755,251.40	960,532.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,081,995.50	1,557,769.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,081,995.50	1,557,769.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	856,338.10	1,097,702.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,063.50	557,095.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,065.30	71,827.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	176,865.70	56,610.6
2104	Хангамж, бараа материалын зардал	57,276.70	51,281.7
2105	Нормативт зардал	2,995.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,238.60	3,000.0
2107	Томилолт, зочны зардал	6,180.00	8,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,413.40	335,683.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,240.00	14,203.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	225,657.40	460,066.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,112,738.40	43,788.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	181,882.90	571,237.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	181,882.90	571,237.0
2200	Дотоод эх үүсвэрээр	181,882.90	571,237.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-181,882.90	-571,237.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-116,000.00	-26,187.5
14	Бусад эх үүсвэр	0.0	22,812.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	116,000.00	49,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	814,855.50	-553,635.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	423,041.20	1,237,896.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,237,896.80	684,260.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,003,373.90	4,003,373.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-105,227.90	-105,227.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,898,146.00	3,898,146.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,027,689.60	-1,027,689.60
9	Тайлант үеийн үр дүн	395,295.90	395,295.90
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,870,456.40	2,870,456.40
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,870,456.40	2,870,456.40

12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	235,654.20	235,654.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,106,110.60	3,106,110.60
19	Тайлант үеийн үр дүн	-140,570.30	-140,570.30
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,812,482.70	2,812,482.70

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,273,656.1	1,748,499.6	525,156.5	76.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,455,504.3	1,158,713.5	296,790.8	79.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,035,554.2	960,755.2	74,799.0	92.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	488,335.4	476,045.6	12,289.8	97.5
210101	Үндсэн цалин	363,842.8	339,447.9	24,394.9	93.3
210102	Нэмэгдэл	121,492.6	129,539.3	-8,046.7	106.6
210104	Урамшуулал	3,000.0	7,058.4	-4,058.4	235.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,216.9	61,056.1	1,160.8	98.1
210201	Тэтгэврийн даатгал	41,678.3	40,769.8	908.5	97.8
210202	Тэтгэмжийн даатгал	5,134.6	5,072.0	62.6	98.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,107.8	4,057.7	50.1	98.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,026.9	1,014.4	12.5	98.8
210205	Эрүүл мэндийн даатгал	10,269.3	10,142.2	127.1	98.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	214,840.2	210,378.9	4,461.3	97.9
210301	Гэрэл, цахилгаан	50,593.0	45,422.1	5,170.9	89.8
210302	Түлш, халаалт	157,250.6	157,960.3	-709.7	100.5
210303	Цэвэр, бохир ус	6,996.6	6,996.6	0.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	43,868.3	40,413.4	3,454.9	92.1
210401	Бичиг хэрэг	8,500.0	7,773.9	726.2	91.5
210402	Тээвэр, шатахуун	23,318.3	23,318.3	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,351.4	2,751.4	600.0	82.1
210404	Ном, хэвлэл	1,060.0	55.0	1,005.0	5.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,300.0	3,264.8	35.2	98.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,338.6	3,250.0	1,088.6	74.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,035.7	28,035.7	2,000.0	93.3
210604	Урсгал засвар	30,035.7	28,035.7	2,000.0	93.3
2107	Томилолт, зочны зардал	8,000.0	8,000.0	0.0	100.0
210702	Дотоод албан томилолт	8,000.0	8,000.0	0.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,049.0	68,818.4	45,230.6	60.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	109,568.0	66,373.4	43,194.7	60.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152.0	1,152.0	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	136.9	0.0	136.9	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	638.1	106.5	531.6	16.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154.0	0.0	154.0	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000.0	933.0	1,067.0	46.7
210807	Газрын төлбөр	400.0	253.5	146.5	63.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,208.7	68,007.2	6,201.5	91.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,208.7	68,007.2	6,201.5	91.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	419,950.1	197,958.3	221,991.8	47.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	413,825.1	193,899.5	219,925.6	46.9
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	413,825.1	193,899.5	219,925.6	46.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,125.0	4,058.8	2,066.3	66.3

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,125.0	720.0	1,405.0	33.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000.0	3,338.8	661.3	83.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	710,520.0	540,786.2	169,733.8	76.1
223001	Бусад хөрөнгө	710,520.0	540,786.2	169,733.8	76.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	107,631.8	49,000.0	58,631.8	45.5
230001	Эргэж төлөгдөх зээл	107,631.8	49,000.0	58,631.8	45.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,273,656.1	2,102,991.7	170,664.4	92.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	336,999.9	328,999.9	8,000.0	97.6
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	336,999.9	328,999.9	8,000.0	97.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	996,292.0	1,752,361.5	-756,069.5	175.9
320001	Орон нутгийн төсвөөс	996,292.0	1,752,361.5	-756,069.5	175.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	940,364.2	21,630.3	918,733.9	2.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,930.0	5,937.7	36,992.3	13.8
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,299.7	15,692.7	-9,393.0	249.1
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	891,134.5	0.0	891,134.5	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	131,805.6	-131,805.6	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	265,150.2	-265,150.2	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,006.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,006.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,412.8
2104	Хангамж. Бараа материалын зардал	200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,212.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,212.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,593.3
0213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,593.3
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,593.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,006.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,006.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,994.8

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн ерөнхий орлого болон төсвийн шууд захирагчийн 4, 1 сум дундын ойн ангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Үүнд:

№	Байгууллагын нэр	Аудитын дүгнэлт
1	Засаг даргын Тамгын газар	Өөрчлөлтгүй дүгнэлт
2	Нарс шинэсэн төгөл ОНӨААТҮГ	Өөрчлөлтгүй дүгнэлт
3	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Түүвэрт хамрагдсан
4	Сум хөгжүүлэх сан	Түүвэрт хамрагдсан

5	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан
---	---------------------------	--------------------

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 719.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 263.6 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 448.5 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 7.1 сая төгрөгийн 8 зөвлөмжийг өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 2,240.3 сая төгрөгийн алдааг илрүүлж аудитын хугацаанд бүрэн залруулсан. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 2,220.5 сая төгрөгийн Хоорондын тооцооны бичилтийг дутуу хийсэн нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалтай нийцэхгүй байгаа алдааг залрууллаа.
- Гүйцэтгэлээр санхүүжиж буй улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлын төвлөрүүлэх шилжүүлэг 1.1 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд хоорондын тооцооны бичилт хийсэн нь Сангийн сайдын 2024 оны 10/683 дүгээр албан бичигтэй тус тус нийцэхгүй байгааг залруулсан.
- Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг нэгтгэхдээ зээлийг урт, богино хугацаагаар ангилж бүртгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан заавар аргачлалтай нийцэхгүй байгаа алдааг залрууллаа.

Аудитаар 48.5 сая төгрөгийн зөрчил илэрч 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл шууд бус орлого 0.1 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.4 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.2 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөр 25.9 сая төгрөгөөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 1.0 сая төгрөгөөр нийт 27.6 төгрөгөөр тус тус тасарсан байна. Аймагт төвлөрүүлэх орлогоос ААНОАТ-ыг 3.5 сая төгрөгөөр, улсад төвлөрүүлэх орлогоос ААНОАТ-ыг 0.4 сая төгрөгөөр тус тус тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

2. Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн 3 иргэнтэй холбоотой 17.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хоцорсон зээл, хүүгийн үлдэгдлийг төвлөрүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цагаан-Үүр сумын ТТЗ	3	2,240.3	3	2,240.3			3	2,240.3				
Дүн	3	2,240.3	3	2,240.3			3	2,240.3	0	0	0	0
Харьяа байгууллагуудын алдаа												
Цагаан-Үүр ЗДТГ	5	229.9	4	229.5	1	0.4	5	229.9				
Нарс шинэсэн төгөл СДОА	1	33.7			1	33.7	1	33.7				
ДҮН	6	263.6	4	229.5	2	34.1	6	263.6	0	0	0	0
НИЙТ ДҮН	9	2,274.0	7	2,469.8	2	34.1	9	2,274.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цагаан-Үүр ТТЗ	2	48.5					2	48.5				
Дүн	2	48.5					2	48.5				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Цагаан-Үүр сумын ЗДТГ	3	7.1					3	7.1				
Нарс шинэсэн төгөл СДОА	4	0.0					4	0.0				
Дүн	7	7.1					7	7.1				
НИЙТ ДҮН	9	55.6					9	55.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТТЗ								
Харьяа байгууллагуудын зөрчил								
Цагаан-Үүр ЗДТГ	1	448.5			1	448.5		
Нарс шинэсэн төгөл СДОА	1	0.0					1	0.0
Дүн	2	448.5			1	448.5	1	0.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	5	2	3		2			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	6	3	3		3			

